



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А152

Чойр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 48.2.3, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Аймгийн 2024 оны төсөвт батлах тухай" 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх зураг төсөв боловсруулах ажлуудын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Болд-Эрдэнэ  
(Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга)

Гишүүд:

Б.Хорол  
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Хөндлөнгийн төлөөлөл:

М.Долгормаа  
(Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн)  
Л.Туяа  
(Сүмбэр сумын 1 дүгээр багийн иргэн)


Нарийн бичгийн дарга:

Г.Номин-Эрдэнэ  
(Аймгийн Худалдан авах ажиллагаа газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах, авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

Баялагдуулсан: Р.Номин-Эрвэл  
Хянагч: Г.Баянзүрэг  
Хувь: 2